

1. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГААС

2023 оны төсвийн бодлого

Монгол Улсын 2023 оны төсвийг Улсын Их хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хэлэлцэн баталсан. 2023 оны төсвийн бодлогоор төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан дараах зорилтуудыг хэрэгжүүлхээр тодорхойлсон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд:

- ✓ Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг боломжит түвшинд хүртэл бууруулах;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа, зардалд тавих хяналтыг сайжруулах замаар төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх;
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, өмнөх жилүүдэд эхлүүлсэн төсөл арга хэмжээг хугацаанд нь дуусгах;
- ✓ Төрөөс хэрэгжүүлж байгаа мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй, үр ашигтай байдлаар өөрчлөн зохион байгуулж, Засгийн газрын дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх;

Төсвийн орлого нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг нэмэгдүүлэх зарчмын хүрээнд:

Засгийн газраас татварын бүртгэлийг сайжруулах, цахимжуулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх замаар далд эдийн засгийг бууруулах, татварын суурийг өргөжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд татвар, гаалийн болон бусад төрийн байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, бараа бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийг өргөжүүлснээр бараа, бүтээгдэхүүн, ашигт малтмалыг үйлдвэрлэл, борлуулалт, импорт, экспортын үе шат бүрээр цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэг, дүгнэлтэд үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Түүнчлэн, цахим төлбөрийн баримтын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд төвлөрсөн зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа болон төлбөрийн баримт олголтын түвшин багатай зарим иргэд, аж ахуйн нэгжүүдийн ажил гүйлгээг бүртгэх, төлбөрийн баримт олгох ажлыг эрчимжүүлнэ

Төсвийн зарлагад хэрэгжүүлэх зарчмын хүрээнд:

1. Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг мөрдөж, хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллана.
2. Бүтээмжтэй уялдсан уян хатан цалин хөлсний шинэчлэлийг эхлүүлнэ.

3. Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа зарим салбаруудад хүрэх үр дүнгийн гүйцэтгэл, үйлчилгээний чанарт нь үндэслэн санхүүжилт хуваарилах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Иймд 2023 онд төрийн албан хаагчдын орлогод шууд нөлөөлөх үр дагавартай цалин хөлстэй холбоотой зардлыг бууруулалгүйгээр төсөвт байгууллагуудын хэмнэх боломжтой үйл ажиллагааны зардлыг бууруулж тооцсон байна.

Түүнчлэн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, бүтээмжтэй уялдсан уян хатан цалин хөлсний тогтолцооны шинэчлэлийг эхлүүлэн, төрийн үйлчилгээ үзүүлж байгаа зарим салбаруудад хүрэх үр дүнгийн гүйцэтгэл, үйлчилгээний чанарт нь үндэслэн санхүүжилт хуваарилах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлнэ.

Мөн 2023 онд төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах болон төсвийн шинэчлэлийн бодлого, төрийн албан хаагчдыг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Нэг. Хуульд зааснаас бусад салбарт дэд, орлогч даргатай холбоотой төсөв хянаж тусгахгүй байх

Хоёр. Төсөвт байгууллагыг хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллуулна. Бүх шатны төсөвт байгууллагын албан бичиг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэн, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх замаар холбогдох зардлыг хэмнэх.

Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино хийх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх.

Дээрх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төсөвт байгууллагын цалин хөлс, байр ашиглалтын тогтмол зардлаас бусад тэвчиж болох урсгал зардлыг 50 хувиар, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлыг 30 хувиар тус тус бууруулсан. /зардлын бууралтыг харуулах

Гурав: Гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ. Төсвийн шинэчлэлийн бодлогын хүрээнд төрийн албан хаагчийг ажлын бүтээмжээр нь урамшуулдаг тогтолцоог бий болгохыг зорьж байна. Төрийн албаны тухай хуулиар албан тушаалын тогтмол үндсэн цалин болон албан тушаалын ангиллаас нь хамаарсан үндсэн цалингаас нь тооцогддог олон төрлийн тогтмол нэмэгдлүүд авч байна. Энэ нэмэгдэл нь ихэвчлэн тухайн төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан тухайн ажлыг гүйцэтгэхэд тавигдах мэдлэг боловсрол, ур чадварууд, хүлээх хариуцлага, ажлын нөхцөл зэрэг шаардлагуудтай давхардаж байна.

Түүнчлэн төрийн албан хаагчийг улирлын 40 хүртэл хувиар олгодог үр дүнгээр урамшуулал нь байгууллагын хэтийн зорилго, цаашлаад мэргэжилтний гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлттэй төдийлөн уялдахгүй байна.

Тиймээс төрийн албан хаагчийн ажлын үр дүнг үнэлэх, биелэлтийг дүгнэх замаар урамшуулдаг, хариуцсан ажил, үүргийн гүйцэтгэлээ сайжруулахад нь түлхэц өгдөг байхаар төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчилнэ.

Дөрөв: Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчийн цалинг нэг суурьтай болгоно. Засгийн газраас 2022 оны 107, 194 дүгээр тогтоолоор эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбарын болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний албан хаагчийн цалинг нэг шатлал бүхий суурь цалинтай болгосон. Ингэхдээ төрийн албан хаагчдын үндсэн цалинг тухайн шатлалын хамгийн дээд түвшин буюу 5 дугаар шатлалд хүргэж ахиулсан бөгөөд үүний үр дүнд үндсэн цалин дунджаар 8.5 хувиар нэмэгдсэн. 2023 онд дээрх зарчмын дагуу төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчийн үндсэн цалинг дээд шатлалаар нь тогтоож, суурь цалинтай болгох арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Тав: Төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгоно. Төрийн захиргааны албан хаагчийг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгоно. Мөн тухайн орон нутаг эдийн засгийн нөөцөө боломжит дээд хэмжээгээр ашигласан, орлогоо давуулан биелүүлсэн бол орон нутгийн удирдлага нь төрийн албан хаагчдынхаа цалинг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгох эрх зүйн орчныг бий болгоно. Төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгохтой холбогдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Зургаа: Төрийн албан хаагчийн ажилласан хугацааны нэмэгдлийг жил тутам тооцон олгодог болно. Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувийн давтамжтай 25 хүртэл хувиар олгодог одоогийн зохицуулалтыг шинэчилж, ажилласан жил бүрээр нь тооцон нэмэгдүүлнэ. Ингэснээр төрийн албан хаагч нь нэг жил ажилласан бол 1 хувь, хоёр дахь жилдээ ажиллавал 2 хувь гэсэн зарчмаар 25 жил ажилласан бол 25 хувийн нэмэгдэл авах ажилласан хугацаанаас хамаарсан цалингийн нэмэгдэл авдаг болно.

Зургаа: Сумын төвд тав болон түүнээс дээш жил ажилласан зарим алба хаагчид мөнгөн урамшуулал олгоно. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 188 дугаар тогтоолын дагуу сумын төвд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгоход шаардагдах 7.3 тэрбум төгрөгийг Монгол Улсын Шадар сайдын 2023 оны төсвийн төсөлд тусгав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно гэж заасны дагуу мөнгөн урамшуулалд шаардагдах 7.7 тэрбум төгрөгийг 2023 оны төсвийн төсөлд тусгав.

Долоо: Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг 2023 онд төлөвлөхдөө зээлийн гэрээний дагуу төлөгдөх төлбөрийн хуваарьт үндэслэсэн. Мөн орон нутгийн Засаг даргын Тамгын Газарт олгосон зээлүүдийн хүрээнд хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөрийг нэмж төвлөрүүлэхээр тооцсон байна.

2. АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН НИЙТЛЭГ ЗАРЧМУУД.

1. Төсвийн орлого, зарлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мөрдөж байгаа болон өөрчлөлт орж батлагдсан хууль журам, тогтоол шийдвэрийг орон нутагтаа нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулж хуваарилах, батлахтай холбоотой Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийг бүрэн хэрэгжүүлэх, урсгал зардлын хяналтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

3. Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх

4. Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2023 онд хэрэгжүүлэх аймгийн Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах эх үүсвэрийг бүрдүүлэн зарцуулахад чиглүүлсэн.

Орон нутгийн орлогод баримталсан зарчим.

Орон нутгийн орлогын төсвийн төсөл боловсруулж хуваарилах, батлахтай холбоотой Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийг хэрэгжүүлэх.

Үүний хүрээнд: Татварын бүртгэлийг сайжруулах, цахимжуулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх замаар татварын суурийг өргөжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Цахим төлбөрийн баримтын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд төвлөрсөн зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа болон төлбөрийн баримт олголтын түвшин багатай зарим иргэд, аж ахуйн нэгжүүдийн ажил гүйлгээг бүртгэх, төлбөрийн баримт олгох ажлыг эрчимжүүлнэ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилгоор хувь хүний орлогын албан татварын шаталсан тогтолцоог нэвтрүүлэхэд анхаарч ажиллах

Хүү торгуулийн орлогыг нэр төрлөөр нь бүрэн бүртгэж гүйцэтгэлийг өндөр байлгахад анхаарах

Аймгийн орлого бүрдүүлэх боломжийг судлан сумын санал, мэргэжлийн байгууллагын санал, аймгийн аудитын газрын зөвлөмж, сүүлийн 3 жилийн орлого бүрдүүлэлтийн байдалд үндэслэн орлогыг зохист түвшинд төлөвлөх.

Хянагдсан суурь орлогд үндэслэн бүрдүүлэх боломжгүй орлогыг бууруулж, зарим орлогыг боломжит хэмжээнд нэмэгдүүлж төлөвлөх.

Төсвийн зарлагад хуваарилахад баримталсан зарчим:

Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийг бүрэн хэрэгжүүлэх. Үүний хүрээнд: Шат шатны хурлын төлөөлөгчдийн урамшууллын зардлыг төсөвлөхгүй байх,

Төрийн албан хаагчийн цалин хөлсний тухайд Төрийн захиргааны ангиллын албан тушаалын үндсэн цалинг дээд шатлалаар нь буюу ТЗ-5 шатлалаар тооцох, хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээ 550,0 мянган төгрөг байхаар тогтоогдож байгаа тул үүнтэй уялдуулан ТҮ-ийн албан хаагчдын цалингийн доод хэмжээг 6 хувиар нэмэгдүүлж төлөвлөх, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ажилласан жилтэй нь уялдуулан нэмэгдлийг шинэчлэн тооцох, төрийн захиргааны албан хаагчийг орон нутагт ажиллах сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор хуваарилагдан ирсэн 20 хувийн нэмэгдэлийг тооцож хуваарилсан. Орон нутгийн нэмэгдлийг 20-100 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгож болох бөгөөд 80 хувийн нэмэгдлийг орон нутаг төсвөө нэмж бүрдүүлж чадсан нөхцөлд олгож болох эрхийг тухайн орон нутаг, удирдлагад олгох замаар шийдвэрлэх боломжийг бий болгосон байна.

Мэргэжлийн хяналтын зарим чиг үүргийг орон нутгийн төсөвт шилжүүлсэнтэй холбогдуулан аймагт 9 улсын байцаагчийн орон тоо ирсэний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын төсөв, орон тоонд нэмж хуваарилсан.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар заалтыг бүрэн хэрэгжүүлэх. Өмнөх жилүүдэд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээс аймаг, суманд гэж хуваарилж байсныг больж 2023 оноос эх үүсвэрийг тухайн орлого орсон суманд нь зарцуулж байх, төлөвлөсөн болон давж биелэсэн орлогыг зориулалт бусаар зарцуулахгүй байх.

Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд нийт эх үүсвэрээс суурь зардал санхүүжүүлэхгүй байж хөгжлийн санд нь бүрэн хуваарилах, тогтвортой амьжиргаа 3 төслийн урамшууллыг сум сумдад нь, үлдсэн хэсгийг журмын дагуу аймаг, сумдад 50, 50 хувиар тооцож хуваарилсан.

2023 ОНЫ ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР

Орон нутгийн байгууллагуудын 2023 оны орлогын эх үүсвэрийг **54,109.8** сая төгрөг байхаар төлөвлөсөн нь 2022 оны тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулбал **-14,078.2** сая төгрөг буюу **-20,6** хувиар буурсан байна.

ТӨСВИЙН ЗАРДАЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР

/ сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны төсөл	2022 он тодотгосон	Нэмэгдэж, хасагдсан зөрүү	Өсөлт, бууралтын хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		55,149.3	68,188.0	-13,038.7	-19.1
1	Туслам Санхүүгийн дэмжлэг	21,972.4	21,748.7	223.7	1.0
2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	11,546.7	8,823.0	2,723.7	30.9
3	Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт		2,130.4	-2,130.4	-100.0
4	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55.2	100.6	-45.4	-45.1
5	Урд оны үлдэгдлээс санхүүжих	1,119.3	13,213.3	-12,094.0	-91.5
6	Орон нутгийн орлого	20,455.7	22,172.0	-1,716.3	-7.7

2023 оны орлогын эх үүсвэрийн өөрчлөлт:

- **Санхүүгийн дэмжлэг:** Санхүүгийн дэмжлэг 21,972.4 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2022 оны тодотгосон төлөвлөгөөнөөс 223.7 сая төгрөг буюу 1 хувиар нэмж батлагдсан.
- **Орон нутгийн хөгжлийн сан:** Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр 11,546.7 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2022 оны төлөвлөгөөнөөс **2,723.7** сая төгрөг буюу 30,9 хувиар өсч батлагдсан байна.
- **Туслах үйл ажиллагааны орлого:** Аймгийн байгаль орчны газар, орон нутгийн өмчийн газар, мал хамгаалах сан болон түрээсийн орон сууцны эргэлтийн сангийн төсвийг тусгасан.
- **Урд оны үлдэгдлээс санхүүжих:** Аймгийн 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл, орон нутгийн хөрөнгө оруулалтын дансны үлдэгдлийг тооцож тусгасан.

ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

2023 оны орон нутгийн нийт орлогыг **20,455.7** сая төгрөг байхаар төлөвлөснийг 2022 оны тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулан үзвэл **-128.5** сая төгрөг буюу **0,6** хувиар буурсан

Орон нутгийн орлогыг 2023 онд **20,455.7** сая төгрөг байхаар төлөвлөснийг 3,778.5 сая төгрөг нь аймгийн орлого, 16,677.2 сая төгрөг нь сумын орлогоос бүрдэж байна. 2022 оны тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулан үзвэл 2023 оны аймгийн орлого **-524.0** сая төгрөг буюу 12,2 хувиар буурсан бол, сумын орлого 395.6 сая төгрөг буюу 2,4 хувиар нэмэгдсэн.

ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ХАРЬЦУУЛАЛТ /аймаг, сумын дүнгээр/

№	Үзүүлэлт	2022 он	2023 он	/сая төгрөгөөр/ Нэмэгдсэн, хасагдсан дүн	
				Тоогоор	Хувиар
	Орон нутгийн орлого	20,584.1	20,455.7	-128.4	-0.6
1	Аймгийн орлого	4,302.5	3,778.5	-524.0	-12.2
2	Сумын орлого	16,281.6	16,677.2	395.6	2.4

2022 онд 23 сумын эмийн эргэлтийн санг дуудлага худалдаагаар худалдан борлуулсны орлого 1,204.0 сая төгрөг аймгийн орлогын төлөвлөгөөнд төлөвлөгдсөн нь 2023 оны аймгийн орлого буурч төлөвлөгдөхөд голлон нөлөөлсөн. 2023 оны аймгийн орлогын төлөвлөлтөд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 836.8 сая төгрөг шинээр нэмэгдэж тусгагдсан. Тус орлогыг Хөвсгөл-Эрчим хүч” ХХК болон “Хөвсгөл-Ус суваг” ХХК-аас бүрдүүлэхээр аймгийн орлогын төсвийн төсөлд тусгасан.

ОРОН НУТГИЙН ОРЛОГО /орлогын нэр төрлөөр/

Д/д	ОРЛОГЫН ТӨРӨЛ	2022 оны	2023 оны	Зөрүү /2023 батлах-2022 төлөвлөгөө/ Төлөвлөгөө/
		Жилийн төлөвлөгөө	Төсөл	
1	НИЙТ ОРЛОГО	20,584.1	20,455.7	-128.5
2	УРСГАЛ ОРЛОГО	19,363.9	20,415.5	1,051.6
3	ТАТВАРЫН ОРЛОГО	17,777.5	17,731.1	-46.4

4	Орлогын албан татвар	11,818.5	11,674.0	-144.5
5	Хувь хүний орлогын албан татвар	12,856.9	12,774.0	-82.9
6	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал ...	9,852.5	9,970.0	117.5
7	Үйл ажиллагааны орлого	511.3	620.0	108.7
8	Хөрөнгө борлуулсны орлого	344.8	350.0	5.2
9	Шууд бус орлого	349.7	400.0	50.3
10	Хадгаламжийн хүүгийн орлогын татвар	1,798.6	1,434.0	-364.6
11	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,038.4	-1,100.0	-61.6
12	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,170.0	582.0	-588.0
13	Өмчийн татвар	1,260.1	1,465.0	204.9
14	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	498.3	673.0	174.7
15	Бууны албан татвар	81.8	80.0	-1.8
16	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан..	680.0	712.0	32.0
17	Бусад татвар	3,528.9	4,010.1	481.2
18	Улсын тэмдэгтийн хураамж	498.8	540.9	42.1
19	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны ...	44.3	75.4	31.1
20	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	463.8	660.0	196.2
21	Газрын төлбөр	509.7	509.6	-0.1
22	Үүнээс: Газрын төлбөр	442.3	409.6	-32.7
23	Газрын дуудлага худалдаа	67.4	100.0	32.6
24	Байгалийн нөөц ашигласны төлбөр Үүнээс:	2,012.3	2,224.2	211.9
25	Ургамал ашигласны төлбөр	25.5	40.9	15.4
26	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	58.4	60.0	1.6
27	Ойн нөөц ашигласны төлбөр	1,746.9	1,953.3	206.4
28	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	181.5	170.0	-11.5
29	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,586.4	2,684.4	1,098.0
30	Ногдол ашиг	267.0	511.7	244.7
31	Хүүгийн орлого	0.0	836.8	836.8
32	Торгуулийн орлого	936.4	950.0	13.6
33	Түрээсийн орлого	44.3	45.9	1.6
34	Нэр заагдаагүй бусад орлого	338.7	340.0	1.3
35	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	1,220.2	40.2	-1,180.0
36	Хөрөнгө борлуулсаны орлого	1,220.2	40.2	-1,180.0
37	НИЙТ ОРОН НУТГИЙН ОРЛОГО: Үүнээс	20,584.1	20,455.7	-128.5
	АЙМГИЙН ОРЛОГО	4,302.5	3,778.5	-524.0
	СУМЫН ОРЛОГО	16,281.6	16,677.2	395.6

Сангийн яамнаас 2023 оны орон нутгийн суурь орлогыг **18,883.7** сая төгрөг байхаар хянаж ирүүлснийг тооцоо судалгаа, аудитын зөвлөмжид үндэслэн **20,455,7** сая төгрөг байхаар төлөвлөж орлогыг **1,572.0** сая төгрөгөөр нэмэгдүүлж, нэмэгдлийг нэн шаардлагатай арга хэмжээнүүдийн зардлын эх үүсвэр болгон хуваариллаа.

-Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал түүнтэй адилтгах орлогын албан татварыг 2023 оны цалингийн сангийн зардлын эх үүсвэртэй уялдуулан 470,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. /Төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 20 хувиар олгох болсон/

-Үйл ажиллагааны зардалд ноос, арьс ширний урамшууллыг тооцон 120,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

-Хадгаламжийн хүүгийн орлогыг энэ оны гүйцэтгэлтэй харьцуулан 2022 оны төлөвлөгөөнөөс -364,6 сая төгрөгөөр бууруулж, Сангийн яамнаас хянасан орлогын төлөвлөгөөнөөс 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

-Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2022 оны гүйцэтгэлтэй уялдуулан 2022 оны төлөвлөгөөнөөс -588.0 сая төгрөгөөр, Сангийн яамнаас хянасан орлогын төлөвлөгөөнөөс 263.0 сая төгрөгөөр бууруулсан.

- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг Сангийн яамнаас суурь дүнгээр хянаж ирүүлснийг нийт орлогод шилжүүлэн 162.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

- Зам ашигласны төлбөрийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн 190,0 сая төгрөг байхаар төлөвлөсөн.

- Хог хаягдлын хураамжийн орлогыг сумын суурин өрхийн тоо, аж ахуйн нэгж байгууллагын тоонд үндэслэн, 2023 онд мөрдөх тарифыг баримтлан 220.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн.

-Ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын суурь үнэ нэмэгдсэнтэй холбогдон 3.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

-Түрээсийн орлогыг 2022 онд олгогдсон эргэн төлөгдөх нөхцөлтэй хадлангийн 4 , хүнсний ногооны 2 тракторын түрээсийн орлогод үндэслэн 25.9 сая төгрөгийг нэмэгдүүлсэн.

Мөн аймгийн Аудитын газраас ирүүлсэн зөвлөмжид үндэслэн орон нутгийн орлогыг 572,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үүнд: Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төрөл болох малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гарал үүслийн хураамжаас орох орлогыг 20.9 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 55.4 сая төгрөгөөр, “Могойн гол” ХК-аас төвлөрүүлэх ногдол ашиг 495,7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН НЭМЭГДЭЛ

/сая төгрөгөөр/

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	2023 оны	2023 оны	Зөрүү /2023 он төсөл-СЯ хянасан/	Өсөлт, бууралтын хувь
		СЯ хянасан суурь орлого	Төсөл		
1	ОРОН НУТГИЙН ОРЛОГО	18,883.7	20,455.7	1572.0	8.3
2	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал,	9,500.0	9,970.0	470.0	4.9
3	Үйл ажиллагааны орлого	500.0	620.0	120.0	24.0
4	Хөрөнгө борлуулсны орлого	350.0	350.0		

5	Шууд бус орлого	400.0	400.0		
6	Хадгаламжийн хүүгийн татвар	1,384.0	1,434.0	50.0	3.6
7	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,100.0	-1,100.0		
8	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	845.0	582.0	-263.0	-31.1
9	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	673.0	673.0		
10	Бууны албан татвар	80.0	80.0		
11	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	550.0	712.0	162.0	29.5
12	Бусад орлого, зам ашигласны төлбөрийн орлого	150.0	340.0	190.0	126.7
13	Улсын тэмдэгтийн хураамж	520.0	540.9	20.9	4.0
14	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	75.4	55.4	277.0
15	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	440.0	660.0	220.0	50.0
16	Газрын төлбөр	409.6	409.6		
17	Газрын дуудлага худалдаа	100.0	100.0		
18	Ургамал ашигласны төлбөр	37.0	40.9	3.9	10.5
19	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	60.0	60.0		
20	Ойн нөөц ашигласны төлбөр	1953.3	1,953.3		
21	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	170.0	170.0		
22	Ногдол ашиг	0.0	511.7	511.7	
23	Хүүгийн орлого	836.8	836.8		
24	Торгуулийн орлого	950.0	950.0		
25	Түрээсийн орлого	20.0	45.9	25.9	129.5
26	Хөрөнгө борлуулсаны орлого	35.0	40.2	5.2	14.9

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР ХУВААРИЛАЛТ

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдсан хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Орон нутгийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг баримталж хуваарилалтыг хийсэн болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 11,546.8 сая төгрөг хуваарилагдснаас итгэлцүүрээр тооцон хуваарилах 10,507.2 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 62.2 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс урамшуулалд 977.4 сая төгрөг хуваарилагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн итгэлцүүрээр тооцон хуваарилах 10,507.2 сая төгрөгнөөс “Төсвийн тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт заасны дагуу 5,253.6 сая төгрөгийг аймагт, 5,253.6 сая төгрөгийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан сумдад хуваарилсан болно.

Хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээг аймгийн статистикийн хэлтсээс гаргасан 2021 оны үзүүлэлтэд үндэслэн хуваарилсан бол алслалтын хэмжээг аймгийн Автотээврийн төвөөс баримталдаг алслалтын хэмжээг үндэслэн төлөвлөсөн.

Орон нутгийн хөгжлийн сангийн “Тогтвортой амьжиргаа”-3 төслөөс 2022 онд 18 сум урамшуулалд хамрагдаж нийт **542.5** сая төгрөгийн санхүүжилт авсан бол 2023 онд 20 сум урамшуулалд хамрагдаж нийт **977.4** сая төгрөгийн санхүүжилтийг авахаар болсон байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	Үүнээс:		
			Итгэлцүүрийн хуваарилалт	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Урамшуулал /Тогтвортой амьжиргаа-3 төсөл/
1	Алаг-Эрдэнэ сум	154.5	145.5	9.0	
2	Арбулаг	183.8	157.2	0.1	26.5
3	Баянзүрх	231.8	191.9		39.9
4	Бүрэнтогтох	197.4	152.8	12.0	32.7
5	Галт	298.8	246.1		52.8
6	Жаргалант	286.4	244.8		41.6
7	Их-Уул	178.9	152.4		26.4
8	Рашаант	184.7	151.4		33.4
9	Рэнчинлхүмбэ	399.7	336.1	1.8	61.8
10	Тариалан	360.4	266.6		93.8
11	Тосонцэнгэл	157.4	134.1		23.3
12	Төмөрбулаг	175.2	144.6		30.6
13	Түнэл	181.7	149.9	1.4	30.4
14	Улаан-Уул	372.7	307.0		65.7
15	Ханх сум	263.2	224.5		38.8
16	Цагаан-Уул	386.6	273.4	17.6	95.6
17	Цагаан-Үүр	273.6	233.1		40.5
18	Цэцэрлэг	378.7	296.6	19.3	62.8
19	Чандмань-Өндөр	170.2	170.2	0.0	0.0
20	Шинэ-Идэр	159.4	130.5	0.0	28.9
21	Хатгал	114.3	114.3	0.0	0.0
22	Мөрөн	758.9	649.4	0.5	109.1
23	Эрдэнэбулган	246.2	203.3		43.0
24	Цагааннуур	178.4	177.9	0.5	0.0
СУМЫН ДҮН		6,293.2	5,253.6	62.2	977.4
25	Аймагт	5,253.6	5,253.6		
Аймгийн нийт дүн		11,546.8	10,507.2	62.2	977.4

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ХУВААРИЛАЛТ

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрт **1833.9** сая төгрөг батлагдаж ирсэнийг байгалийн нөөц ашигласны төлбөрийн хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээгээр тооцон ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын 15 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувиар, газрын төлбөрийн орлогын 15 хувиар, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувиар, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувиар тус тус тооцон тухайн орлого орсон сумын төсөвт нь бүрэн хуваарилан тооцов.


БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

/сая төгрөгөөр/

№	Сумдын дүн	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал	Ургамлын нөөц ашигласны төлбөр		Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого		Газрын төлбөр		Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого		Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	
			Төлөв лөгөө	БХНСАХ-ий зардалд	Төлөв лөгөө	БХНСАХ-ий зардалд	Төлөв лөгөө	БХНСАХ-ий зардалд	Төлөв лөгөө	БХНСАХ-ий зардалд	Төлөв лөгөө	БХНСАХ-ий зардалд
			15%		50%		15%		85%		35%	
1	Алаг-Эрдэнэ	71.0	1.2	0.2	0.1	0.1	32.8	4.9	76.5	65.1	2.2	0.8
2	Арбулаг	32.3	0.2	0.0	9.5	4.7	2.6	0.4	31.9	27.1	0.2	0.1
3	Баянзүрх	63.7	0.2	0.0	14.8	7.4	5.8	0.9	65.0	55.3	0.2	0.1
4	Бүрэнтогтох	38.3	0.3	0.0	0.2	0.1	7.0	1.1	42.5	36.1	2.8	1.0
5	Галт	87.8	1.7	0.3	0.7	0.4	5.7	0.9	100.2	85.2	3.2	1.1
6	Жаргалант	214.0	3.6	0.5	0.9	0.5	5.8	0.9	249.1	211.7	1.2	0.4
7	Их-Уул	60.8	1.0	0.2	0.2	0.1	5.0	0.8	70.0	59.5	0.9	0.3
8	Рашаант	56.3	0.1	0.0	2.4	1.2	11.6	1.7	62.5	53.1	0.5	0.2
9	Ренчин лхүмбэ	97.8	8.5	1.3	57.8	28.9	5.7	0.9	78.1	66.4	0.9	0.3
10	Тариалан	102.4	1.6	0.2	1.9	1.0	29.0	4.4	113.5	96.5	1.0	0.4
11	Тосонцэнгэл	43.7	0.0	0.0	0.1	0.0	4.2	0.6	50.3	42.7	0.9	0.3
12	Төмөрбулаг	34.5	0.2	0.0	1.6	0.8	2.2	0.3	38.9	33.1	0.9	0.3
13	Түнэл	98.7	2.8	0.4	0.1	0.1	13.0	2.0	112.5	95.6	2.0	0.7
14	Улаан-Уул	64.0	3.9	0.6	1.5	0.8	3.5	0.5	73.0	62.1	0.3	0.1
15	Ханх	49.0	1.2	0.2	3.2	1.6	18.6	2.8	51.6	43.9	1.6	0.6
16	Хатгал	114.5	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	128.2	109.0	15.7	5.5
17	Цагааннуур	35.8	3.1	0.5	0.4	0.2	4.0	0.6	40.5	34.4	0.2	0.1
18	Цагаан-Уул	77.4	0.9	0.1	26.9	13.4	4.4	0.7	74.1	62.9	0.7	0.2
19	Цагаан-Үүр	113.9	1.9	0.3	7.7	3.9	5.5	0.8	128.0	108.8	0.4	0.1
20	Цэцэрлэг	56.3	2.5	0.4	24.3	12.1	5.5	0.8	49.6	42.1	2.3	0.8
21	Чандмань-Өндөр	137.5	2.3	0.3	2.4	1.2	10.5	1.6	157.8	134.2	0.8	0.3
22	Шинэ-Идэр	21.9	0.1	0.0	0.1	0.1	2.6	0.4	24.9	21.2	0.6	0.2
23	Эрдэнэ булган	122.7	2.8	0.4	12.8	6.4	10.0	1.5	134.5	114.3	0.3	0.1
24	Мөрөн	39.5	0.7	0.1	0.2	0.1	214.6	32.2	0.0	0.0	20.2	7.1
25	Нийт дүн	1833.9	40.9	6.1	170.0	85.0	409.6	61.4	1953.3	1660.3	60.0	21.0

АЙМГИЙН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН ЗАРЛАГЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ

Улсын Их Хурлаас батлагдсан аймгийн 2023 оны төсвийн орон нутгийн суурь зарлага 40,554.0 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2022 оны УИХ-аас батлагдан ирсэн төсвөөс 3,593.4 сая төгрөг буюу 8.1 хувиар буурсан байна. Энэ нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдийн цалин улсын төсөвт шилжсэн, засаг даргын нөөц хөрөнгийг 1,0 тэрбум төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.



Орон нутгийн төсвийн зардал

2023 оны батлагдаж ирсэн төсвийг 2022 онтой харьцуулсан байдал:

(сая төгрөг)

Үзүүлэлт	2022 бат	2023 бат	Зөрүү	
			Дүнгээр	Хувиар
Хөвсгөл	44,524.5	40,931.1	-3,593.4	-8.1%
УРСГАЛ ЗАРДАЛ	43,238.6	39,224.9	-4,013.7	-10.2%
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,958.3	29,944.9	6,986.6	23.3%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	8,513.6	11,448.1	2,934.5	25.6%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,064.2	1,431.0	366.8	25.6%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,978.6	15,103.5	3,124.9	20.7%
Хангамж, бараа материалын зардал	641.3	854.1	212.8	24.9%
Нормативт зардал	298.5	363.2	64.7	17.8%
Эд хогшил, урсгал засварын зардал	345.3	539.0	193.7	35.9%
Томилолт, зочны зардал	116.9	206.0	89.1	43.3%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,470.7	5,828.0	-10,642.7	-182.6%
Бараа үйлчилгээний бусад зардал	1,600.5	519.5	-1,081.0	-208.1%
ХҮҮ	5.2	836.8	831.6	99.4%
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	5.2	836.8	831.6	99.4%
ТАТААС	267.6	560.3	292.7	52.2%
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	49.5	355.4	305.9	86.1%
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	218.1	204.9	-13.2	-6.4%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,941.5	1,535.4	-406.1	-26.5%
Бусад урсгал шилжүүлэг	1,941.5	1,535.4	-406.1	-26.5%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,286.0	1,928.9	642.9	33.3%

Дээрхээс харахад Цалин хөлс болон хувьсах зардлууд 20-26 хувийн өсөлттэй байна. Энэ нь албан хаагчдийн цалингийн үндсэн болон нэмэгдэл цалинийн өсөлттэй холбоотой. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал буурсан нь улсын төсвөөс цалинжих болсон байгууллагуудын нийтлэг үйлчилгээний зардал буюу төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хасагдсантай болсонтой бууралт юм. Урсгал шилжүүлэг 26 хувиар буурсан нь сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмж 2022 онд батлагдсан байсантай холбоотой болно.

Мөн Орон нутгийн нөөц хөрөнгө ковидын нөхцөл байдалтай холбогдуулан 2021, 2022 онуудад 1,3 тэрбум төгрөгөөр батлагдан ирж байсан бол 2023 онд 1,0 тэрбум төгрөгөөр бууруулан баталж ирүүлсэн байна. 1999 оноос хойш аймагт дамжуулан зээлдүүлэх гэрээнээр Ус суваг, нийтийн аж ахуйн чиглэлээр болон эрчим хүч, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын зээлийн эргэн төлөлтийн зардлыг 1,5 тэрбум төгрөгөөр тооцон ирүүлсэн байгаа нь эдгээр зардлын өсөлт бууралтад гол нөлөөг үзүүлж байна.

Сангийн яамнаас батлагдаж ирсэн төсвийг зардлын зүйлээр харьцуулахад ийм байдалтай байгаа бөгөөд ажиллах явцад нэмэгдүүлсэн орлого, эх үүсвэрийг хуваарилсан байдлаар үргэлжлүүлэн танилцуулья.

Аймгийн орон нутгийн төсвийн хуваарилалт:

(сая төгрөг)

ДД	Байгууллага	2022 батлагдсан	2023 Яамнаас ирсэн	2023 батлах	Зөрүү
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	576.6	496.8	475.8	(100.8)
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	3,173.2	2,476.2	2,574.5	(598.7)
3	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,504.8	1,995.3	2,039.4	534.6
4	Сумын Засаг даргын Тамгын газар	11,549.6	10,764.0	13,226.5	1,676.9
5	"Засаг дарга" ерөнхий данс бусад	1,070.4	1,461.4	1,619.4	549.0
6	Мал эмнэлгийн үйлчилгээ	657.5	671.6	671.6	14.1
8	Усны алдагдлын татаас	285.8	308.8	308.8	23.0
9	Ариун цэврийн байгууламж	218.1	205.0	205.0	(13.1)
10	Ахмадын хороо	64.1	62.5	62.5	(1.6)
11	Авто замын сан	860.0	902.0	902.0	42.0
12	Агаарын бохирдлын эсрэг	45.4	42.6	42.6	(2.8)
13	Мал хамгаалах сан	21.6		26.9	5.3
14	Санхүү хяналт, аудитын алба	193.8	191.2	191.2	(2.6)
15	Орон нутгийн өмчийн газар	220.9	216.2	216.2	(4.7)
16	Асрамжийн газар	451.9	561.5	561.5	109.6
17	Байгаль орчин аялал жуулчлалын газар	1,622.8	2,967.2	1,133.3	(489.5)
18	Ойн анги	156.2	202.4	202.4	46.2
19	Хот тохижилт үйлчилгээний төв	881.9	1,178.2	1,178.2	296.3
20	Халамж	962.6	1,191.5	1,191.5	228.9
21	Түрээсийн орон сууцны эргэлтийн сан	-		17.2	17.2
22	Орон нутгийн хөрөнгө оруулалт	749.9	1,928.9	2,937.4	2,187.5
23	Соёл, спортын байгууллагууд	1,863.6	1,740.5	1,740.5	(123.1)
24	Боловсрол, эрүүл мэнд	20,527.3	11,367.3	11,367.3	(9,160.0)
Дүн		47,657.9	40,931.1	42,891.7	(4,766.2)

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын төсвийн хуваарилалтын талаар:

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагуудын 2023 оны зарлагын төсөв 2,039.5 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2022 оны батлагдсан төсвөөс 534.7 сая төгрөг, 2021 оны төсвөөс 636.3 сая төгрөгөөр тус тус өссөн бол аймгийн ИТХ-ын төсөв мөн өсөлттэй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолын дагуу нэмэгдсэн орон тоотой холбоотой цалин шимтгэлийн зардлын өсөлт байна.

Сумын ЗДТГ-ын тухайд үндсэн орон тоог 324-р, багийн засаг даргын орон тоог 128-р хянаж баталж ирүүлсэн. Харин төрийн үйлчилгээний албан хаагчдийн орон тоог хянаж ирүүлээгүй тул цалингийн санг нь өмнөх оны түвшинээс бууруулахгүйгээр тооцон хуваарилсан болно.

(сая төгрөг)

Үзүүлэлт	2021 УИХ Бат	2022 УИХ Бат	2023 УИХ Бат	Зөрүү (2023-2022 он)
Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,403.2	1,504.8	2,039.5	534.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,327.2	1,423.7	2,029.5	605.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,038.8	1,078.9	1,519.4	440.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137.8	134.9	189.9	55.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2.4	1.0		-1.0
Хангамж, бараа материалын зардал	74.7	69.6	98.0	28.4
Нормативт зардал	0.8	0.8	1.4	0.6
Эд хогшил, урсгал засварын зардал	26.6	12.7	20.0	7.3
Томилолт, зочны зардал	17.3	8.6	10.0	1.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /Гэм хэргээс урьдчилан сэргийлэх зардал орсон/	11.3	99.5	160.4	60.9
Бараа үйлчилгээний бусад зардал	17.7	17.7	30.4	12.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76.0	81.2	10.0	-71.2
Бусад урсгал шилжүүлэг	76.0	81.2	10.0	-71.2

Харин сумдын Засаг даргын Тамгын 2023 оны зарлагын төсөв 13,226.4 сая төгрөгөөр батлагдахаар хуваарилагдсан нь 2022 оны батлагдсан төсвөөс 1,676.7 сая төгрөг, 2021 оны төсвөөс 4,223.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

(сая төгрөг)

Үзүүлэлт	2021 УИХ Бат	2022 УИХ Бат	2023 УИХ Бат	Зөрүү (2021-2020 он)
Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	9,003.4	11,549.7	13,226.4	1,676.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,753.3	10,072.7	13,045.8	2,973.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	6,102.2	5,582.4	7,525.4	1,943.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	823.8	660.3	940.7	280.4
Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	973.3		-973.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	788.1	780.2	1,287.0	506.8
Хангамж, бараа материалын зардал	528.4	420.8	518.0	97.2
Нормативт зардал	5.3	5.3	5.0	-0.3
Эд хогшил, урсгал засварын зардал	100.9	104.3	80.0	-24.3

Томилолт, зочны зардал	136.9	69.7	104.8	35.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /Байгалт хамгаалах нөхөн сэргээх зардал орсон/	234.3	1,001.0	2,305.2	1,304.2
Бараа үйлчилгээний бусад зардал /Орон нутгийн нөөц хөрөнгө болон баяр наадмын зардал орсон/	33.4	475.4	279.7	-195.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250.1	633.6	180.6	-453.0
Бусад урсгал шилжүүлэг	250.1	633.6	180.6	-453.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	843.322	0	-843.3
Их засвар	0	843.322		-843.3

Сумдад хуваарилагдсан хувьсах зардал:

Хувьсах зардлыг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалтын индексээр тооцож дараах байдлаар хувиарласан. 2023 онд хувьсах зардал нийт дүнгээрээ 345,2 сая төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс ИТХ 153,5 сая төгрөгөөр, ЗДТГ 191,7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

(мянган төгрөг)

№	Сумын нэр	2023 онд хуваарилсан			2022 оноос өөрчлөгдсөн зөрүү		
		ИТХ	ЗДТГ	НИЙТ ДҮН	ИТХ	ЗДТГ	НИЙТ ДҮН
1	Алаг-Эрдэнэ	11,371	39,416	50,786	5,365	7,940	13,305
2	Арбулаг	8,727	41,692	50,419	5,262	8,744	14,006
3	Баянзүрх	10,312	50,362	60,675	5,848	7,918	13,766
4	Бүрэнтогтох	8,697	39,592	48,289	5,293	6,428	11,722
5	Галт	11,404	55,696	67,100	6,334	7,494	13,828
6	Жаргалант	11,100	54,211	65,311	6,352	9,069	15,422
7	Их-Уул	8,820	39,703	48,523	5,140	6,698	11,838
8	Рашаант	9,132	43,714	52,846	5,354	7,796	13,150
9	Рэнчинлхүмбэ	13,487	78,401	91,888	7,600	8,416	16,016
10	Тариалан	11,581	56,557	68,137	6,479	8,050	14,529
11	Тосонцэнгэл	8,471	34,601	43,072	5,328	5,571	10,899
12	Төмөрбулаг	9,149	36,914	46,063	5,712	6,593	12,306
13	Түнэл	8,785	36,832	45,617	5,253	5,101	10,354
14	Улаан-Уул	12,907	75,568	88,474	6,368	8,890	15,258
15	Ханх	15,079	72,640	87,719	7,912	9,256	17,168
16	Цагаан-Уул	13,304	63,019	76,322	7,235	8,174	15,410
17	Цагаан-Үүр	14,004	71,277	85,281	7,457	9,029	16,486
18	Цэцэрлэг	14,625	76,306	90,931	7,636	9,862	17,498
19	Чандмань-Өндөр	11,189	49,758	60,947	6,738	7,443	14,180
20	Шинэ-Идэр	10,992	39,565	50,557	7,726	7,811	15,537
21	Хатгал	0	33,027	33,027	0	5,174	5,174
22	Мөрөн	22,446	120,271	142,717	11,339	14,670	26,008
23	Эрдэнэбулган	13,732	62,180	75,912	7,637	7,081	14,718
24	Цагааннуур	14,835	67,567	82,402	8,120	8,475	16,595
25.0	Нийт	274,150	1,338,865	1,613,014	153,488	191,685	345,173

Орон нутгийн нөөц хөрөнгийн хуваарилалт: Орон нутгийн нөөц хөрөнгөд 300 сая төгрөг батлагдаж ирсэн бөгөөд боломжид тулгуурлан аймагт 252 сая төгрөг, сум тус бүрт 2.0 сая төгрөг хуваарилахаар тооцлоо.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал: Энэ жил 148,4 сая төгрөг батлагдаж ирсэн бөгөөд аймагт 102,4 сая төгрөг, сум тус бүрт 2 сая төгрөг байхаар хувиарласан.

Баяр наадмын зардал: Улсын Их Хурлаас 100 сая төгрөг батлагдснаас сум тус бүрт 3.0 сая төгрөг, аймгийн баяр наадмын зардалд 28 сая төгрөгийг хуваариласан.

Халамжийн үйлчилгээний зардлын талаар :

Халамжийн үйлчилгээний 11 төрлийн зардал батлагддаг байснаас 2019 оноос эхлэн гурван үйлчилгээ орон нутагт үлдэж бусад үйлчилгээний зардал нь улсын төсөвт шилждэг болсон. 2023 онд 1,191.5 сая төгрөг батлагдан ирсэн нь 2022 оны батлагдсан төсвөөс 228.9 сая төгрөгөөр өссөн бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардалд 76.8 сая, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийн зардалд 180.0 сая төгрөг, нийгмийн халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээний зардал буюу цаатан иргэдийн тэтгэмжийн зардалд 934.7 сая төгрөг хуваарилагдсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих соёл урлаг, спортын байгууллагуудын төсөв:

Боловсрол, эрүүл мэндийн болон соёлын салбарын байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбогдуулан 2022 онд орон нутагт батлагдсан байсан байр ашиглалтын үйлчилгээний буюу ТҮ-ийн албан хаагчдийн цалин хасагдаж байр ашиглалтын тогтмол зардал, урсгал засварын зардлууд орон нутгаас санхүүжхээр батлагдсан.

2023 оны төсөвт орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын байр ашиглалтын зардал /гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир ус түрээс, урсгал засвар/-ны зардлыг батлагдсан ирсэн дүнд нь багтаан сум байгууллагаар хуваарилсан болно. Тогтмол зардлаас гэрэл цахилгааны зардал 25 хувиар нэмэгдэж тооцогдсон бол түлш халаалтын зардал шинээр ашиглалтад орох барилга объект, талбайн хэмжээгээр нэмэгдэж ирсэн.

(сая төгрөг)

№	Байгууллага	2022 онд батлагдсан төсөв	2023 онд батлагдсан төсөв	Зөрүү
1	Эрүүл мэнд	912.4	987.9	75.5
2	Соёл	978.9	1,259.7	280.8
3	Ерөнхий боловсрол	7,117.4	7,723.7	606.3
4	Сургуулийн өмнөх	2,157.4	2,430.6	273.2
	Нийт	11,166.1	12,401.9	1,235.8

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС**